



## УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ ЭМНЭЛЭГ

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,  
Энхтайваны өргөн чөлөө 49, Утас/Факс: (976) 7015 0308  
И-мэйл: info@ssch.gov.mn, Вэб: www.ssch.gov.mn

АЖ АХУЙН НЭГЖ  
БАЙГУУЛЛАГУУДАД

2025. 02. 10 № 4/144  
танай -ны № -т

Хамтран ажиллах хүсэлт  
хүргүүлэх тухай

Улсын хоёрдугаар төв эмнэлэг нь Эрүүл мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д заасны дагуу “Хувь хүн, гэр бүл, хамт олонд эрүүл мэндийн боловсрол олгох, хүн амын дунд эрүүл мэндийг дэмжих орчныг бүрдүүлэх талаар бусад байгууллагатай хамтран ажиллах” үүрэг хүлээсэн эрүүл мэндийн байгууллага юм.

Мөн хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1.2-д зааснаар аж ахуйн нэгж, байгууллага нь “Өөрийн байгууллагын ажилтны эрүүл мэндийг дэмжих, өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох арга хэмжээг эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийн дагуу зохион байгуулах” үүрэг хүлээсэн байна.

Тус эмнэлэг танай байгууллагын ажилчид болон үйлчлүүлэгч иргэдэд “Лабораториид суурилсан төрөлжсөн нарийн мэргэшлийн эмчийн үзлэг оношилгоо”-г хамгийн хямд өртгөөр чанартай, стандартын дагуу, өөрийн эмнэлэг дээр болон явуулын үзлэг, лабораторийн төлбөрт тусламж, үйлчилгээ үзүүлэх хэлбэрээр зохион байгуулж, өвчнийг эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээг шуурхай хийж, иргэдийн эрүүл мэндийг нь дэмжин ажиллах боломжтой байна.

Иймд та бүхнийг Эрүүл мэндийн тухай хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх ажлын хүрээнд ажилтнууд болон үйлчлүүлэгчдийнхээ эрүүл мэндийг хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, амьдралын чанарыг нь дээшлүүлэх чиглэлээр манай эмнэлэгтэй хамтран ажиллахыг урьж байна.

Утас: 70150209, 99559035

Цахим хаяг: procurement@ssch.gov.mn

ЗАХИРАЛ

Б.БЯМБАДОРЖ

ATA13284 9077146  
9024090350

2025.02.10